




ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2025 VIII



dornogovi.nso.mn



Сайншанд
2025 он



**ДОРНОГОВЬ
АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС**

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл

Үндсэн үзүүлэлтүүд

I. Хөдөлмөр

II. Нийгмийн даатгал, халамж

III. Эрүүл мэнд

IV. Гэмт хэрэг

V. Мөнгө, банк, зээл

VI. Төсөв, санхүү

VII. Хэрэглээний үнийн индекс

VIII. Мал аж ахуй

IX. Аж үйлдвэр

X. Барилга

XI. Байгаль орчин

Хавсралт хүснэгтүүд

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- ... мэдээлэл байхгүй
- 0.0 маш бага тоо
- - гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- # тухайн сар

III. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

- мянга =1000
- сая =10
- тэрбум =10
- их наяд =10¹²
- % хувь
- мм миллиметр
- см сантиметр
- дм дециметр
- м метр
- км километр
- м² метр квадрат
- дм² дециметр квадрат
- км² километр квадрат
- м³ метр куб
- га гектар
- мл миллилитр
- л литр
- г грамм
- кг килограмм
- Вт ватт
- кВт цкиловатт цаг
- калкалори ккалкилокалори
- Гкал гигакалори(=10⁹ калори)
- мкг/м³ микрограмм метр куб
-  Үүнээс гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

ХЯНАСАН:

Х.Өлзийсүрэн

Хэлтсийн дарга

БЭЛТГЭН БОЛОВСРУУЛСАН:

Б.Цэрэндорж

Аж үйлдвэр, Бизнес регистрийн сан
хариуцсан Ахлах мэргэжилтэн

Б.Энхцэцэг

Худалдаа, үйлчилгээний салбар
хариуцсан мэргэжилтэн

Б.Мөнхчимэг

Хөдөө аж ахуйн салбар
хариуцсан мэргэжилтэн

ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Нутгийн удирдлагын ордон, 216 тоот

Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103

Утас: 70522749, 70520008

Цахим хуудас: www.dornogovi.nso.mn

Цахим шуудан: dornogovi@nso.mn

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII
Нийгмийн даатгалын сангийн орлого	сая төгрөг	40 233.3	51 738.6	60 592.4
Нийгмийн даатгалын сангийн зарлага	сая төгрөг	57 422.7	70 323.9	82 350.2
Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ	сая төгрөг	47 554.0	63 802.4	74 467.8
Нийгмийн халамжийн сангийн зарцуулалт	сая төгрөг	28 737.0	31 826.3	32 984.5
Хамрагдсан хүн	тоо	45531	50512	46633
Төрөлт	хүн	735	691	578
Нас баралт	хүн	262	243	285
Эхийн эндэгдэл	хүн	1	...	1
Нялхсын эндэгдэл	хүн	10	8	6
Халдварт өвчнөөр өвчлөгчид	хүн	1205	751	734
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	489	614	515
Гэмт хэргийн улмаас нас барсан хүн	хүн	32	28	14
Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ	сая төгрөг	2 924.4	4 848.3	5 265.7
Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт	сая төгрөг	883.0	2 728.0	654.4
Банкны салбар нэгж	тоо	58	58	56
Зээлийн үлдэгдэл	сая төгрөг	371 863.9	510 740.5	622 920.7
Хадгаламжийн үлдэгдэл	сая төгрөг	177 614.0	231 679.0	251 168.9
Орон нутгийн төсвийн орлого	сая төгрөг	57 800.1	74 221.7	73 918.0
Орон нутгийн төсвийн зарлага	сая төгрөг	71 287.3	66 902.2	84 221.7
Хэрэглээний үнийн индекс (өмнөх сартай харьцуулсан)	хувь	0.9	0.9	1.3
Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны мөн үетэй харьцуулсан)	хувь	11.7	6	8.3
Зүй бусаар хорогдсон мал	толгой	111 735	613 986	356
Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт	сая төгрөг	251 365.7	309 337.2	279 313.0
Аж үйлдвэрийн салбарын борлуулалт	сая төгрөг	675 364.2	600 250.5	398 308.8



ХӨДӨЛМӨР

I-VIII/2025

Тархаасан: 2025 оны 9 дүгээр сарын 15

Ажил хайгч иргэдийн тоо 8 дугаар сард 122 болжээ.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны 8 дугаар сарын мэдээгээр ажил хайгч иргэдийн тоо 122 болсоны 71 (71.8%) эмэгтэйчүүд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажил хайгч иргэд 57 хүнээр буюу 87.7 хувиар өсжээ. Тайлант хугацаанд 33 иргэн нэмэгдэж, 67 иргэн хасагдсан байна.

ХҮСНЭГТ 1.1 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨН, жил бүрийн 8 дугаар сард

Үзүүлэлт	2024 VIII	2025 VIII	2025 VIII 2024 VIII	
			Өөрчлөлт	Хувь
Хүн				
Ажил хайгч иргэн /сарын эхэнд/	80	156	76	95.0
Үүнээс эмэгтэй	41	84	43	104.9
Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн	46	33	-13	-28.3
Үүнээс эмэгтэй	29	12	-17	-58.6
Тайлант хугацаанд хасагдсан иргэн	61	67	6	9.8
Үүнээс эмэгтэй	36	25	-11	-30.6
Ажил хайгч иргэн /сарын эцэст/	65	122	57	87.7
Үүнээс эмэгтэй	34	71	37	108.8

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

Тайлант хугацаанд нэмэгдсэн 33 ажил хайгч иргэдийг шалтгаанаар авч үзвэл 14 (42.4%) иргэн цалин орлого хүрэлцэхгүй байгаа, 12 (36.4%) иргэн бусад, 5 (15.2%) иргэн шилжин суурьшсан, 1 (3.0%) Эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй болсон, 1 (3.0%) иргэн одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй зэрэг шалтгааны улмаас ажил хайгч иргэнээр бүртгүүлжээ.

ЗУРАГ 1.1 АЖИЛ ХАЙГЖ БАЙГАА ИРГЭД, нэмэгдсэн шалтгаанаар 8 дугаар сард



Бүлэг 1. Хөдөлмөр эрхлэлт

Ажил хайгч иргэдийн боловсролын түвшинг харахад 37 (30.3%) бүрэн дунд, 28 (23.0%) дипломын болон бакалаврын дээд, 20 (16.4%) суурь, 17 (13.9%) техник болон мэргэжлийн, 7 (5.7%) бага, 7 (5.7%) тусгай мэргэжлийн, 5 (4.1%), боловсролгүй, 1 (0.8%) нь магистр, докторын боловсролтой иргэд байна.


ХҮСНЭГТ 1.2 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР 8 ДУГААР САРД

Боловсролын түвшингээр	2024 VIII	2025 VIII	2025 VIII 2024 VIII	
			Өөрчлөлт	Хувь
Хүн				
Нийт	65	122	57	87.7
Үүнээс: Эмэгтэй	34	71	37	2.1 ²
Магистр, доктор		1	1	0.0
Дипломын болон бакалаврын дээд	14	28	14	2.0 ²
Тусгай мэргэжлийн дунд	6	7	1	16.7
Техник болон мэргэжлийн	7	17	10	2.4 ²
Бүрэн дунд	28	37	9	32.1
Суурь	9	20	11	2.2 ²
Бага	1	7	6	7.0 ²
Боловсролгүй		5	5	0.0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

Оны 8 сарын байдлаар 261 иргэн ажилд зуучлагдсаны 123 буюу 47.1 хувь нь эмэгтэйчүүд байна. Өмнөх оны мөн үеэс ажилд зуучилсан нийт иргэдийн тоо 273 (51.1%-ээр, эмэгтэйчүүд 71 (36.6%-ээр тус тус буурсан байна.

ЗУРАГ 1.2 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, 8 ДУГААР САРД



Хөдөлмөрийн хэлтсийн мэдээллээр ажлын байрны захиалга 736 болж, өмнөх оны мөн үеэс 290 (28.3%-ээр буурчээ.

Бүлэг 1. Хөдөлмөр эрхлэлт

Шинэ ажлын байранд орсон иргэдийн тоо 656 болж, өмнөх оны мөн үеэс 307 (53.2%)-оор өссөн байна. Ажлын байрны шинж чанараар нь авч үзэхэд 573 буюу 87.3 хувь нь байнгын ажлын байраар хангагджээ.

ХҮСНЭГТ 1.3 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, шинж чанараар, 8 сард

Салбарын ангилал	2024 I-VIII	2025 I-VIII		Бүгдээс:Ажлын байрны шинж, чанараар		
		Бүгд	Эмэгтэй	Байнга	Улирал	Түр
	Хүн					
Бүгд	349	656	274	573	22	61
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	7	66	25	66		
Уул уурхай, олборлолт	47	123	32	108	4	11
Боловсруулах үйлдвэрлэл	39	98	30	88	10	
Цахилгаан, хий, уур агааржуулалт	8	0				
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа		1		1		
Барилга	6	55	23	53		2
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	111	54	10	50	1	3
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	63	47	13	47		
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	0	8	6	8		
Мэдээлэл холбоо	0	1	1	1		
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0	2	2	2		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0	8	5	8		
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	22	1	1	1		
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	21	105	63	55	6	44
Боловсрол	20	38	27	38		
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	3	42	32	40	1	1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0	6	4	6		
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1	0				
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	1	1		1		

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

Ойлголт тодорхойлолт

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн

Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийн хөдөлгөөнийг ойлгоно.

Ажил хайгч иргэн:

Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.

Эх үүсвэр:

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Мэдээлэл авах холбоос:

<https://dornogovi.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь

2025 оны 10 дугаар сарын 15

Дорноговь аймгийн статистикийн хэлтсийн
дарга Х. Өлзийсүрэн
Утас : 70520008

Худалдааны салбар хариуцсан мэргэжилтэн
Б. Энхцэцэг
Утас 70522749



НИЙГМИЙН ДААТГАЛ

I-VIII /2025

Тархаасан: 2025 оны 9 дугаар сарын 15

Тэтгэвэр авагчдын тоо өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар нэмэгджээ.

Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 8 дугаар сарын байдлаар 60592.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8853.7 (17.1%) сая төгрөгөөр өссөн бөгөөд төлөвлөгөөнөөс 6.7 хувиар дутуу биелсэн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 8853.7 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сан 8011.2 сая төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сан 862.8 сая төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сан 971.4 сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 2.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, төрлөөр

	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII		2025 I-VIII 2024 I-VIII	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
сая төгрөг						
Нийт дүн	40 233.3	51 738.6	64 934.3	60 592.4	8 853.7	17.1
Тэтгэврийн даатгал	32 665.0	41 634.7	54 895.5	49 645.9	8 011.2	19.2
Тэтгэмжийн даатгал	3 438.6	4 388.3	4 826.4	5 251.1	862.8	19.7
ҮОМШӨ*-ны даатгал	3 447.9	4 826.3	3 382.2	3 834.7	- 991.6	-20.5
Ажилгүйдлийн даатгал	681.8	889.3	1 830.2	1 860.7	971.4	109.2

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс

Нийгмийн даатгалын сангийн зарлага 82350.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 12026.3 (17.1%) сая төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 73614.6 (89.4%) сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 4934.9 (6.0%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 2895.3 (3.5%) сая төгрөг, ҮОМШӨ*-ны даатгалын сангаас 905.4 (1.1%) сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

ХҮСНЭГТ 2.2 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр

Үзүүлэлт	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII		2025 I-VIII 2024 I-VIII	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
сая төгрөг						
Нийт дүн	57 422.7	70 323.9	84 242.7	82 350.2	12 026.3	17.1
Тэтгэврийн даатгал	49 558.6	63 172.8	75 282.3	73 614.6	10 441.8	16.5
Тэтгэмжийн даатгал	3 067.2	4 020.9	4 832.0	4 934.9	914.0	22.7
ҮОМШӨ*-ны даатгал	2 849.7	1 061.9	1 125.9	905.4	- 156.5	-14.7
Ажилгүйдлийн даатгал	1 947.2	2 068.3	3 002.5	2 895.3	827.0	40.0

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс

ЗУРАГ 2.1

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2025 оны 8 дугаар сарын байдлаар



Нийгмийн даатгалын сангийн нийт орлогод тэтгэврийн даатгалын сан 81.9 хувийг, тэтгэмжийн даатгалын сан 8.7 хувийг, ҮОМШӨ*-ны даатгалын сан 6.3 хувийг, ажилгүйдлийн даатгалын сан 3.1 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ҮОМШӨ*-ний даатгалын сангийн эзлэх хувь 3.0 хувиар буурсан бол тэтгэврийн даатгалын сан 1.5 нэгж хувиар, ажилгүйдлийн даатгалын сан 1.4 нэгж хувиар, тэтгэмжийн даатгалын сан 0.2 нэгж хувиар тус тус нэмэгджээ.

Нийгмийн даатгалд даатгуулагчид 8 дугаар сард 28989 болж, өмнөх оны мөн үеэс 3414(13.3%)-аар өсжээ. Нийт даатгуулагчдын 24991 нь албан журмаар, 3998 нь сайн дураар даатгуулсан иргэд байна. Албан журмаар даатгуулагчдын 15759 (63.1%) нь аж нэгж байгууллагын ажилчид бол 9232 (36.9%) нь төсөвт байгууллагын ажилчид байна.

ХҮСНЭГТ 2.3


НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, төрлөөр

Үзүүлэлт	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	2025 I-VIII 2024 I-VIII	
				Өөрчлөлт	Хувь
Хүн					
Дүн	21 575	25 575	28 989	3 414	13.3
Албан журмаар даатгуулагчид	18 66	22 068	24 991	2 923	13.2
Аж ахуйн нэгж байгууллага	10 600	12 837	15 759	2 922	22.8
Төсөвт байгууллага	8 076	9 231	9 232	1	0.0
Сайн дураар даатгуулагчид	2 899	3 507	3 998	491	14.0

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс

ЗУРАГ 2.2

НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, төрлөөр, дүнд эзлэх хувиар



Нийт даатгуулагчдын дүнд 86.2 хувийг албан журмын, 13.8 хувийг сайн дурын даатгуулагчид эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад албан журмаар даатгуулагчид 0.1 нэгж хувиар буурч, сайн дураар даатгуулагчид 0.1 нэгж хувиар нэмэгджээ.

Бүлэг 2. Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын 8 дугаар сарын байдлаар 10828 хүн, 74467.8 сая төгрөгийн тэтгэвэр авсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэвэр авагчдын тоо 302 (2.9%-аар, олгосон тэтгэвэр 10665.4 (16.7%) сая төгрөгөөр тус тус нэмэгджээ.

ХҮСНЭГТ 2.4 ТЭТГЭВЭР АВАГЧИД БОЛОН ОЛГОСОН ТЭТГЭВЭР, төрлөөр

Үзүүлэлт	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	2025 I-VIII 2024 I-VIII	
				Өөрчлөлт	Хувь
Хүн					
Нийт дүн	10 194	10 526	10 828	302	2.9
Өндөр насны тэтгэвэр	7 639	7 989	8 220	231	2.9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	1 401	1 373	1 390	17	1.2
Тэжээгчээ алдсаны тэтгэмж	477	491	506	15	3.1
Цэргийн тэтгэвэр	556	563	600	37	6.6
ҮОМШӨ*-ний	121	110	112	2	1.8
Олгосон тэтгэвэр, сая төгрөгөөр					
Нийт дүн	47 554.0	63 802.4	74 467.8	10 665.4	16.7
Өндөр насны тэтгэвэр	35 718.0	48 561.9	56 889.2	8 327.3	17.1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	5 090.4	6 190.1	7 002.8	812.7	13.1
Тэжээгчээ алдсаны тэтгэмж	1 849.8	2 256.3	2 660.2	403.9	17.9
Цэргийн тэтгэвэр	4 260.5	6 164.5	7 054.6	890.1	14.4
ҮОМШӨ*-ний	635.3	629.6	861.0	231.4	36.8

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс

Нийт тэтгэвэр авагчдын 8220 (75.9%) нь өндөр насны тэтгэвэр, 1390 (12.8%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр, 600 (5.5%) нь цэргийн тэтгэвэр, 506 (4.7%) нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 112 (1.0%) нь ҮОМШӨ*-ний тэтгэвэр байна.

ЗУРАГ 2.3 ОЛГОСОН ТЭТГЭВЭР, дүнд эзлэх хувиар, 2025 оны 8 дугаар сарын байдлаар



Олгосон тэтгэвэр тэтгэмжийн 76.4 хувийг нь өндөр насны тэтгэвэр, 9.4 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, 9.5 хувийг цэргийн тэтгэвэр, 3.6 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэмж, 1.2 хувийг ҮОМШӨ*-ний тэтгэвэр тус тус эзэлж байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 46633 иргэнд 32984.5 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад хамрагдсан иргэдийн тоо 3879 (7.7%-өөр буурч, олгосон тэтгэвэр, тэтгэмж 1158.2 (3.6 %) сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

ЗУРАГ 2.4 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ



Нийгмийн халамжид хамрагдсан хүний 46633 (91.5%) иргэн нь бусад халамжид, 1325 (2.8%) иргэн нь халамжийн тэтгэвэрт, 1350 (2.9%) иргэн нь халамжийн тэтгэмжид, 1262 (2.7%) иргэн нь амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид тус тус хамрагджээ.


ХҮСНЭГТ 2.5 ХАЛАМЖИД ХАМРАГДСАН ХҮН, төрлөөр

Үзүүлэлт	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	2025 I-VIII 2024 I-VIII	
				Өөрчлөлт	Хувь
Хүн					
Нийт дүн	45 531	50 512	46 633	-3 879	-7.7
Халамжийн тэтгэвэр	1 290	1 245	1 325	80	6.4
Халамжийн тэтгэмж	996	1 143	1 350	207	18.1
Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	998	1 094	1 262	168	15.4
Бусад халамжийн дүн	42 231	47 008	42 678	-4 330	-9.2
Нийгмийн халамжийн сан	16	22	18	-4	-18.2

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

Халамжийн сангаас 8 сарын байдлаар 25011.4 (75.8%) сая төгрөгийг бусад төрлийн халамжид, 3986.8 (12.1%) сая төгрөгийг халамжийн тэтгэвэрт, 2968.6 (9.0%) сая төгрөгийг халамжийн тэтгэмжид, 996.1 (3.0%) сая төгрөгийг амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид, 21.6 сая төгрөгийг нийгмийн халамжийн санд тус тус зарцуулсан байна.

ЗУРАГ 2.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2025 оны 8 дугаар сарын байдлаар



Бүлэг 2. Нийгмийн даатгал, халамж

Бусад төрлийн халамжийн дүнд 11 төрлийн халамжийн тэтгэмжийг тооцсон бөгөөд 85.0 хувийг хүүхдийн мөнгөн тэтгэмж эзэлж байна. Аймгийн хэмжээнд 27266 хүүхдэд 21262.9 сая төгрөгийг олгожээ.

ХҮСНЭГТ 2.6 БУСАД ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр

Үзүүлэлт	Хамрагдсан хүн				Олгосон тэтгэвэр, тэтгэмж			
	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	2025 I-VIII 2024 I-VIII	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	2025 I-VIII 2024 I-VIII
				хувь				хувь
	Хүн				сая төгрөг			
Бүгд	42 231	47 002	42 678	-9.2	23 894.1	24 743.4	25 011.4	1.1
Жирэмсэн эхийн тэтгэмж	433	1 064	894	-16.0	135.5	124.2	106.8	-14.0
ХБИ-д үзүүлэх тусламж	196	190	203	6.8	77.4	81.0	108.5	34.0
Хүнс тэжээл	718	628	550	-12.4	63.6	57.6	35.8	-37.8
Алдар цолтой ахмад	3	6	6		1.1	1.1	2.4	2.0 ²
Алдарт эхийн одонгийн тусламж	5 568	5 706	5 870	2.9	701.0	909.8	1 449.2	59.3
Насны хишиг	3 134	3 348	3 810	13.8	496.8	524.9	560.8	6.8
Цалинтай ээж	2 645	3 481	2 768	-20.5	1 021.4	972.3	865.7	-11.0
Өрх толгойлсон эх/эцэгт	245	239	257	7.5	266.1	304.3	346.5	13.9
Ихэр хүүхэдтэй өрх	8	5	6	20.0	16.0	10.0	14.0	40.0
Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт	4 811	5 761	1 048	-81.8	280.1	487.4	258.8	-46.9
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	24 470	26 574	27 266	2.6	20 835.1	21 270.8	21 262.9	0.0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

Бусад халамжийн сангийн зарцуулалтаас харахад 1449.2 сая төгрөгийг алдарт эхийн одонгийн мөнгөнд, 865.7 сая төгрөгийг цалинтай ээж хөтөлбөрийн тэтгэмжид, 560.8 сая төгрөгийг насны хишгийн зардалд, 346.5 сая төгрөгийг өрх толгойлсон эцэг/эхэд, 258.8 сая төгрөгийг ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжид, 108.5 сая төгрөгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт тусламжид, 106.8 сая төгрөгийг жирэмсэн эхийн тэтгэмжид, 35.8 сая төгрөгийг хүнс тэжээлийн дэмжлэгт, 14.0 сая төгрөгийг ихэр хүүхэдтэй өрхөд тус тус зарцуулсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж

Эх үүсвэр:

Нийгмийн даатгалын хэлтэс
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Мэдээлэл авах холбоос:

<https://dornogovi.nso.mn/>

Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн дарга Х.Өлзийсүрэн Утас: 70520008

даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2025 оны 10 дугаар сарын 15

Аж үйлдвэрийн салбарын мэдээ, бизнес регистрийн сан хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Цэрэндорж Утас: 70522749



ЭРҮҮЛ МЭНД

I-VIII /2025

Тархаасан: 2025 оны 9 дүгээр сарын 15

Оны эхний 8 дугаар сард 578 хүүхэд шинээр мэндэлжээ.

Эрүүл мэндийн газраас ирүүлсэн мэдээллээр 2025 оны эхний 8 дугаар сарын байдлаар амбулаторийн үзлэгт 307.6 мянган хүн хамрагдаж, 11.0 мянган хүн эмнэлэгт хэвтэн

эмчлүүлжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад амбулаторийн үзлэг 7.3 (2.4%) мянган хүнээр нэмэгдэж, хэвтэн эмчлүүлсэн хүн 78.7 (87.7%) мянган хүнээр буурсан.

ХҮСНЭГТ 3.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	2025 I-VIII 2024 I-VIII	
				Өөрчлөлт	хувь
Мянган хүн					
Амбулаторын үзлэг	307.0	300.3	307.6	7.3	2.4
Эмчлүүлсэн хүн	92.0	89.7	11.0	-78.7	-87.7
Ор хоног	92.0	89.7	77.6	-12.1	-13.5
Урьдчилан сэргийлэх тарилга	6.8	6.2	7.6	1.4	22.2
Түргэн тусламжийн дуудлага	10.8	10.7	10.4	-0.3	-2.6
Үүнээс: алсын дуудлага	1.6	1.3	1.1	-0.2	-16.1

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

Мөн урьдчилан сэргийлэх тарилгад 7.6 мянган хүн хамрагдаж, 10.4 мянган удаа түргэн тусламжийн дуудлага гарсаны 10.6 хувь буюу 1.1 мянга нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад түргэн тусламжийн

дуудлага 0.3 (2.6%) мянган хүнээр, алсын дуудлага 0.2 (16.1%) мянган хүнээр тус тус буурсан бол урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан хүн 1.4 (22.2%) мянган хүнээр нэмэгджээ.

ЗУРАГ 3.1 ОСОЛ ГЭМТЛИЙН ӨВЧЛӨЛ



Осол гэмтлийн өвчлөл 2309 бүртгэгдэж, үүний улмаас 69 хүн нас барсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад осол гэмтлийн өвчлөл 305 (15.2%)-аар, нас барсан хүний тоо 22 (46.8%)-оор өсжээ.

Бүлэг 3. Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд оны эхний 8 дугаар сарын байдлаар 869 эх жирэмсний хяналтанд орсны 89.2 хувь буюу 775 эх эхний 3 сартайдаа хяналтанд орсон байна. Өмнөх оны мөн үетэй

харьцуулахад жирэмсний хяналтанд орсон нийт эхчүүд 11 (1.3%)-оор буурч, эхний 3 сартайдаа хяналтанд орсон эхчүүд 7 (0.9%)-аар нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 3.2 АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД


Үзүүлэлт	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	2025 I-VIII 2024 I-VIII	
				Өөрчлөлт	хувь
Хүн					
Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	933	880	869	- 11	-1.3
Үүнээс: эхний 3 сартайд	848	768	775	7	0.9
Амаржсан эх	735	691	578	-113	-16.4
Үүнээс: нас баралт	1
Амьд төрсөн хүүхэд	737	696	578	-118	-17.0
Нялхсын эндэгдэл /0-1 хүртэлх нас/	10	8	6	1	-25.0
Эндсэн хүүхэд /1-5 хүртэлх нас/	2	4	1	-3	-75.0

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

Он гарсаар 578 эх амаржиж, 578 хүүхэд шинээр мэндэлжээ. Өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 113 (16.4%)-аар, төрсөн хүүхдийн тоо 118 (17.0%)-аар тус тус буурсан бөгөөд эхийн эндэгдэл 1 бүртгэгдсэн байна. Нялхсын

эндэгдэл 6, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 3.2 НАС БАРАЛТ



Нас барсан хүний тоо 2025 оны 8 дугаар сарын байдлаар 285 болж, өмнөх оны мөн үеэс 42 (17.3%)-оор нэмэгдсэн байна.

Нас барсан иргэдийг өвчний шалтгаанаар нь авч үзэхэд 24.2 хувийг осол, гэмтэл хордлого гадны шалтгаант үхэл, 21.4 хувийг цусны эргэлтийн тогтолцооны өвчин,


20.7 хувийг хавдрын өвчлөл, 18.6 хувийг амьсгалын тогтолцооны өвчин, 15.1 хувийг бусад төрлийн өвчин тус тус эзэлж байна.

ЗУРАГ 3.3

НАС БАРАЛТ, өвчний шалтгаанаар, дүнд эзэлх хувиар



ЗУРАГ 3.4 ХҮН АМЫН ЦЭВЭР ӨСӨЛТ



Хүн амын төрөлт, нас баралтын зөрүүгээр илэрхийлэгддэг үзүүлэлтийг хүн амын цэвэр өсөлт гэнэ. 2025 оны 8 дугаар сарын байдлаар хүн амын цэвэр өсөлт 293 болсон нь өмнөх оны мөн үеэс 160 (35.3%)-аар буурав.

ЗУРАГ 3.5 ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, 1000 хүнд ногдохоор



Оны эхний 8 дугаар сард 1000 хүнд ногдох төрөлт 8.1, нас баралт 4.0 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 1.6 нэгж хувиар буурч, нас баралт 0.6 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Халдварт өвчний тоо 734 болж, өмнөх оны мөн үеэс 17 (2.3%)-оор буурсан байна. Өмнөх оны мөн үеэс халдварт өвчин 2.3 хувиар буурахад салхин цэцэг 73 (21.0%)-ээр, цусан суулга 51 (77.3%)-аар, тэмбүү 3 (6.1%)-ээр, трихомонаиз 5 (27.8%)-аар тус тус буурсан нь нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 3.3 ХАЛДВАРТ ӨВЧИН, ТӨРЛӨӨР

Үзүүлэлт	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	2025 I-VIII 2024 I-VIII	
				Өөрчлөлт	хувь
Хүн					
Халдварт өвчин	1205	751	734	-17	-2.3
Вируст гепатит	2	3
Сүрьеэ	44	30	35	5	16.7
Тэмбүү	37	49	46	-3	-6.1
Заг хүйтэн	104	120	127	7	5.8
Трихомонаиз	34	18	13	-5	-27.8
Цусан суулга	80	66	15	-51	-77.3
Салхин цэцэг	384	347	274	-73	-21.0
Бусад	520	118	224	106	89.8


Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН

Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн мэдээллээр оны эхний 8 дугаар сарын байдлаар эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 11970.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс

2617.1 (28.0%) сая төгрөгөөр, эрүүл мэндийн сангийн тусламж үйлчилгээний зардал 29364.0 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2428.8 (9.0%) сая төгрөгөөр тус тус нэмэгджээ.

ЗУРАГ 3.6 ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА



Эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж үйлчилгээний зардлыг төрлөөр нь авч үзэхэд лавлагаа шатлалын байгууллагын тусламж үйлчилгээний зардалд 16888.0 (57.5%) сая төгрөг, сумын эрүүл мэндийн төвийн тусламж


үйлчилгээний зардалд 8848.0 (30.1%) сая төгрөг, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний зардалд 2063.3 (7.0%) сая төгрөгийг, хөнгөлөлттэй эмийн зардалд 1572.6 (5.4%) сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 3.5 ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, зарцуулалтын төрлөөр

Үзүүлэлт	2024 I-VIII	2025 I-VIII	2024 I-VIII 2025 I-VIII	
			Өөрчлөлт	хувь
Сая төгрөг				
Дүн	26 935.0	29 363.9	2 428.9	9.0
Лавлагаа шатлалын байгууллагын тусламж үйлчилгээ	16 700.0	16 880.0	180.0	1.1
Сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ	7 015.0	8 848.0	1 833.0	26.1
Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ	1 932.0	2 063.3	131.3	6.8
Хөнгөлөлттэй эмийн тусламж үйлчилгээ	1 288.0	1 572.6	284.6	22.1

Эх үүсвэр: Эрүүл мэндийн даатгалын хэлтэс

ЗУРАГ 3.6 ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ХАМРАГДАГЧИД, ТӨРЛӨӨР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР



Эрүүл мэндийн даатгалд 73274 иргэн даатгуулсан байна. Нийт даатгуулагчийн 53666 (73.2%) иргэн нь шимтгэлийг улсын төсвөөс хариуцсан иргэд, 15814 (21.6%) иргэн нь шимтгэлийг ажил олгогч, даатгуулагч хариуцан төлсөн иргэд, 3794 (5.2%) иргэн нь шимтгэлийг өөрөө хариуцан төлсөн иргэд байна.

Бүлэг 3. Эрүүл мэнд

Ойлголт, тодорхойлолт

Төрөлт: Хүн төрөлхтний дунд явагдаж буй нөхөн үржихүйн бодит үзэгдэл бөгөөд эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоогоор хэмжигдэнэ.

Төрөлтийн ерөнхий коэффициент: Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлнэ.

Нас баралт: Хүн төрөлхтний дунд гарч буй нөхөн үжихүйн үзэгдлийн нэг. Хүн амын амьжиргааны түвшин, амьдралын хэв маяг, эрүүл ахуйн нөхцөл,

өвчлөл нь нас баралтын түвшинд нөлөө үзүүлдэг учир энэ үзүүлэлтийг нас баралтын шалтгаанаар нь тодорхойлж болно.

Нас баралтын ерөнхий коэффициент: Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох нас баралтын тоог илэрхийлнэ.

Хүн амын ердийн цэвэр өсөлт, бууралт: Тухайн жилийн хүн амын төрөлт, нас баралтын тооны зөрүүгээр илэрхийлэгдэнэ.

Эх үүсвэр:

Эрүүл мэндийн газар

Мэдээлэл авах холбоос:

<https://dornogovi.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2025 оны 10 дугаар сарын 15

Дорноговь аймгийн Статистикийн хэлтсийн
дарга Х.Өлзийсүрэн Утас: 70520008



ГЭМТ ХЭРЭГ

I-VIII /2025

Тархаасан: 2025 оны 9 дугаар сарын 15

Гэмт хэргийн улмаас 8 дугаар сард 14 хүн нас баржээ.

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 515 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 99 (16.1%)-өөр буурчээ. Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 188 буюу 36.5 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 12.4 нэгж хувиар буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 4 (4 дахин)-өөр, бусад төрлийн гэмт хэрэг 14 (56.0)-өөр, хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын

журмын эсрэг гэмт хэрэг 51 (61.4%)-ээр, хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 2 (28.6%)-оор тус тус нэмэгдсэн байна. Харин хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 5 (50%)-аар, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын 3 (15.8%)-аар, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 47 (30.7 %)-оор, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 2 (13.3%)-оор тус тус буурсан байна. Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг өмнө оны мөн үетэй адил байна.

ХҮСНЭГТ 4.1 ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр

Үзүүлэлт	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	2025 I-VIII 2024 I-VIII	
				Өөрчлөлт	хувь
Хүн					
Бүгд	489	614	515	-99	-16.1
Хүний амьд явах эрхийн эсрэг	17	10	5	-5	-50.0
Хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг	22	19	16	-3	-15.8
Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан	113	153	106	-47	-30.7
Өмчлөх эрхийн эсрэг	273	300	188	-112	-37.3
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	3	7	9	2	28.6
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	4	1	4	3	4.0 ²
Хүрээлэн байгаа орчны эсрэг	5	15	13	-2	-13.3
Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг	31	83	134	51	61.4
Эрүүл мэндийн эсрэг	2	1	1	0	0.0
Бусад гэмт хэрэг	19	25	39	14	56.0

Эх үүсвэр: Цагдаагийн газар

ЗУРАГ 4.1 ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, 2025 оны 8 дугаар сарын байдлаар



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 68.7 хувь буюу 354 нь хөнгөн хэлбэрийн гэмт хэрэг бол үлдсэн 31.3 хувь буюу 161 нь хүнд хэлбэрийн гэмт хэрэг бүртгэгджээ.

ЗУРАГ 4.2 ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, дүнд эзлэх хувиар



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 36.5 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 26.0 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 20.6 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 16.9 хувийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад гэмт хэрэг 4.2 нэгж хувиар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 12.5 нэгж хувиар тус тус нэмэгджээ. Харин өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 12.4 нэгж хувиар, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 4.3 нэгж хувиар тус тус буурав.

ЗУРАГ 4.3 ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр



Гэмт хэргийн улмаас 8 дугаар сарын байдлаар 379 хүн хохирч, 141 хүн гэмтэж, 14 хүн нас барсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хохирсон хүн 186 (32.9%)-аар, гэмтсэн хүн 47 (25.0%)-оор, нас барсан хүн 14 (50.0%)-өөр тус тус буурсан.

ХҮСНЭГТ 4.2 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН ХҮН

Үзүүлэлт	Хохирсон хүн		Гэмтсэн хүн			
			Гэмтсэн хүн		Нас барсан хүн	
	2024 I-VIII	2025 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII
Нийт	565	379	188	141	28	14
0-17 насны	36	27	11	13	4	0
18-34 насны	192	132	79	54	4	5
35-54 насны	271	180	83	61	13	7
55-аас дээш насны	66	40	15	13	7	2
Эх үүсвэр: Цагдаагийн газар						


Бүртгэгдсэн гэмт хэргийг үйлдэгдсэн газраар авч үзэхэд 147 (28.5%) нь бусад газарт, 125 (24.3%) нь авто замд, 110 (21.4%) нь гэр орон сууцандаа, 68 (13.2%) нь гудамж талбайд, 35 (6.8%) нь аж ахуйн нэгж, 30 (5.8%) нь олон нийтийн газарт тус тус үйлдэгджээ.

ХҮСНЭГТ 4.3 ГЭМТ ХЭРЭГ, үйлдэгдсэн газар

Үзүүлэлт	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	2025 I-VIII 2024 I-VIII	
				Өөрчлөлт	хувь
Бүгд	489	614	515	-99	-16.1
Гэр орон сууцанд	154	136	110	-26	-19.1
Гудамж талбайд	70	78	68	-10	-12.8
Олон нийтийн газарт	29	45	30	-15	-33.3
Аж ахуйн нэгжид	31	38	35	-3	-7.9
Авто замд	30	81	125	44	54.3
Бусад газарт	175	236	147	-89	-37.7
Эх үүсвэр: Цагдаагийн газар					

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 54.3 хувиар нэмэгдэж, аж ахуйн нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг 7.9 хувиар, гудамж талбайд үйлдсэн гэмт хэрэг 12.8 хувиар, гэр орон сууцандаа үйлдсэн гэмт хэрэг 19.1 хувиар, олон нийтийн газарт үйлдэгдсэн нь 33.3 хувиар, бусад газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 37.7 хувиар тус тус буурсан байна.

ЗУРАГ 4.4 ГЭМТ ХЭРЭГ, үйлдэгдсэн цагаар, 2025 оны 8 дугаар сарын байдлаар



Бүлэг 4. Гэмт хэрэг

Гэмт хэргийг үйлдэгдсэн цагаар авч үзэхэд 32.4 хувь нь 06.00-14.00 цагийн хооронд, 27.7 хувь нь 14.00-19.00 цагийн хооронд, 26.4 хувь нь 22.00-06.00 цагийн хооронд, 13.5 хувь нь 19.00-22.00 цагийн хооронд тус тус үйлдэгджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.00-19.00 цагийн хооронд үйлдэгдсэн гэмт хэрэг 1.9 нэгж хувиар, 06.00-14.00 цагийн хооронд үйлдэгдсэн гэмт хэрэг 2.7 нэгж хувиар тус тус нэмэгдсэн бол 19.00-22.00 цагийн хооронд үйлдэгдсэн гэмт хэрэг 1.0 нэгж хувиар, 22.00-06.00 цагийн

үйлдэгдсэн гэмт хэрэг 3.5 нэгж хувиар тус тус буурав.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 5265.7 сая төгрөгийн хохирол учирсанаас 654.4 (12.4%) сая төгрөг нөхөн төлөгдсөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад учирсан хохирол 417.0 (8.6%) сая төгрөгөөр нэмэгдэж, нөхөн төлүүлэлт 2073.0 (76.0 %) сая төгрөгөөр буурчээ.

ЗУРАГ 4.5 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ, сая төгрөгөөр



ЗӨРЧИЛ


Аймгийн хэмжээнд 2025 оны 8 дугаар сарын байдлаар 32550 зөрчил бүртгэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 1534 (4.9%) зөрчлөөр нэмэгджээ. Нийт бүртгэгдсэн зөрчлийн 32097 (98.6%) зөрчлийг торгууль шийтгэл оногдуулж, 217 (0.7%) зөрчлийг баривчилж шийдвэрлэжээ. Харин 236 зөрчил буюу 0.7 хувь нь шийдвэрлэгдээгүй үлдсэн байна.

ХҮСНЭГТ 4.4 БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ, төрлөөр

Үзүүлэлт	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	2025 I-VIII 2024 I-VIII	
				Өөрчлөлт	хувь
Бүгд	22 761	31 016	32 550	1 534	4.9
Торгууль шийтгэл оногдуулсан	22 406	30 699	32 097	1 398	4.6
Баривчилсан	322	175	217	42	24.0
Шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрчил	33	142	236	94	66.2

Эх үүсвэр: Цагдаагийн газар

ЗУРАГ 4.6 БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ, үйлдэгдсэн цагаар, 2025 оны 8 дугаар сарын байдлаар



Бүртгэгдсэн зөрчлийн 12922 (41.6%) нь 12.00-18.00 цагийн хооронд, 9266 (29.8%) нь 18.00-24.00 цагийн хооронд, 7613 (24.5%) нь 06.00-12.00 цагийн хооронд, 1282 (4.1%) нь 24.00-06.00 цагийн хооронд тус тус үйлдэгджээ.

Бүлэг 4. Гэмт хэрэг

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт гэмт хэргийн 12.00-18.00 цагийн хооронд үйлдэгдсэн нь 308 нэгж хувиар, 06.00-12.00 цагийн хооронд үйлдэгдсэн нь 1.1 нэгж хувиар тус тус буурч, 18.00-24.00 цагийн хооронд үйлдэгдсэн нь 2.7 нэгж хувиар, 24.00-06.00 цагийн хооронд үйлдэгдсэн нь 1.4 нэгж хувиар тус тус нэмэгдэв.

ЗУРАГ 4.7 ЗӨРЧИЛ, төрлөөр, дүнд эзлэх хувиар



Нийт бүртгэгдсэн зөрчлийн 32550 буюу 93.2 хувь нь бэлэн бус зөрчил бол 2388 буюу 6.8 хувь нь хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээн шалгасан зөрчил байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хялбаршуулсан журмаар зөрчийн хэрэг нээн шалгасан зөрчлийн эзлэх хувь 0.5 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 2388 буюу 6.8 хувь нь хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээн шалгасан зөрчил бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 279 (13.2%)-оор өссөн байна. Харин зөрчлийн төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн зөрчил хамгийн өндөр буюу 401 (26.6%)-аар нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 4.5 БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ, төрлөөр

Үзүүлэлт	2024 I-VIII	2025 I-VIII	Зөрчлийн бүтэц		
			2025 I-VIII 2024 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII
			Өөрчлөлт	хувь	
Бүгд	2109	2388	279	100.0	100.0
Олон нийтийн газарт биеэ зүй бусаар авч явах	17	4	-13	0.8	0.2
Танхайрах	97	90	-7	4.6	3.8
Хүний биед халдах	113	63	-50	5.4	2.6
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай	150	185	35	7.1	7.7
Тамхины хяналтын тухай хууль зөрчсөн	7	6	-1	0.3	0.3
Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчсөн	42	25	-17	2.0	1.0
Хүүхдийн эрхийг зөрчих	22	24	2	1.0	1.0
Эд хөрөнгө устгах, гэмтээх	22	19	-3	1.0	0.8
Худалдаа, үйлчилгээний журам зөрчсөн	14	2	-12	0.7	0.1
Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих	1507	1908	401	71.5	79.9
Авто замын байгууламж, тэмдэг, тэмдэглэлийг гэмтээх, өөрчлөх, бохирдуулах	28	6	-22	1.3	0.3
Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд саад учруулах	22	17	-5	1.0	0.7
Хуурамч дуудлага мэдээлэл өгөх	25	8	-17	1.2	0.3
Мал махны үйлдвэрлэл, худалдаа эрхлэх журам зөрчсөн	3	5	2	0.1	0.2
Бусад	40	26	-14	1.9	1.1


Эх үүсвэр: Цагдаагийн газар

Бүлэг 4. Гэмт хэрэг

Хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээн шалгасан зөрчлийг төрлөөр нь дүнд эзлэх хувиар авч үзэхэд дийлэнх буюу 79.9 хувийг хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн зөрчил, 7.7 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зөрчил, 3.8 хувийг танхайрах зөрчил, 2.6 хувийг хүний биед халдах зөрчил, 1.0 хувийг архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зөрчил, 5.0 хувийг бусад төрлийн зөрчил эзэлж байна.

ЗУРАГ 4.8

ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР БОЛОН ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ НЭЭН ШАЛГАСАН ЗӨРЧИЛ, дүнд эзлэх хувиар, 2025 оны 8 дугаар сарын байдлаар



Хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээн шалгасан зөрчлийн 2152 (90.1%) нь шийдэгдэж, торгууль шийтгэл оногдуулсан бол үлдсэн 236 (9.9%) нь шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрчил байна.

Хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээн шалгасан зөрчлийг үйлдэгдсэн газраар авч үзэхэд 1882 (78.8%) нь авто зам дээр, 271 (11.3%) нь гэр, орон сууцандаа, 120 (5.0%) нь гудамж талбайд, 48 (2.0%) нь олон нийтийн газарт, 32 (1.3%) нь бусад газарт, 15 (0.6%) нь аж ахуйн нэгж дээр, 2 (0.1%) нь төрийн байгууллага дээр, 18 (0.8%) нь төрийн бус байгууллага дээр тус тус үйлдэгдсэн зөрчлүүд байна.

ХҮСНЭГТ 4.6

ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР БОЛОН ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ НЭЭН ШАЛГАСАН ЗӨРЧИЛ, үйлдэгдсэн газраар

Үзүүлэлт	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	2025 I-VIII 2024 I-VIII	
				Өөрчлөлт	хувь
Бүгд	1941	2109	2388	279	13.2
Авто замд	1419	1455	1882	427	29.3
Гэр орон сууцанд	244	295	271	-24	-8.1
Гудамж талбайд	119	153	120	-33	-21.6
Бусад газар	62	47	32	-15	-31.9
Олон нийтийн газар	70	110	48	-62	-56.4
Төрийн байгууллага	10	23	2	-21	-91.3
Аж ахуйн нэгж	17	25	15	-10	-40.0
Төрийн бус байгууллага		1	18	17	18 ²

Эх үүсвэр: Цагдаагийн газар

Хялбаршуулсан журмаар болон зөрчлийн хэрэг нээн шалгасан зөрчилд холбогдох 2152 иргэнийг нийгмийн байдлаар авч үзэхэд ажилгүй 899 иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч 633 иргэн, бусад хэлбэрийн 184 иргэн, малчин 171 иргэн, хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч 113 иргэн, төрийн албан хаагч 90 иргэн байна.

ХҮСНЭГТ 4.7

ЗӨРЧИЛ ГАРГАСАН ИРГЭН АЛБАН ТУШААЛТАН, НИЙГМИЙН БАЙДЛААР

Үзүүлэлт	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	2025 I-VIII 2024 I-VIII	
				Өөрчлөлт	хувь
Бүгд	1913	1967	2152	185	9.4
Ажилгүй	785	774	899	125	16.1
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	367	479	633	154	32.2
Малчин	199	211	171	-382	-19.0
Бусад	177	175	184	-359	5.1
Хувийн хэвшилд ажиллагч	232	170	113	-283	-33.5
Төрийн албан хаагч	87	87	90	-177	3.4
Төрийн бус байгууллагад ажиллагч	41	20	19	-39	-5.0
Оюутан	13	27	22	-5	-18.5
Сурагч	12	21	20	-1	-4.8
Тэнэмэл		3	1	-2	-66.7

Эх үүсвэр: Цагдаагийн газар

Бүлэг 4. Гэмт хэрэг

Эх үүсвэр:

Цагдаагийн газар

Мэдээлэл авах холбоос

